



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

НЭГ ХОТ
СТАНДАРТ

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ



СТАТИСТИКИЙН
ТАНИЛЦУУЛГА



www.ubstat.mn



www.facebook.com/ubstat

2020
11 САР



АГУУЛГА

Хуудасны
дугаар

	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2016-2020 ОН	1
	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	2
	БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	3
	НИЙГМИЙН ДААТГАЛ	6
	ЭРҮҮЛ МЭНД	8
	АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	11
	ГЭМТ ХЭРЭГ	16
	ТӨСӨВ	19
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	22
	АЖ ҮЙЛДВЭР	30
	ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	35
	ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ	36

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн XI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020
Шинээр төрсөн хүүхэд	тоо	37 466 ↓2.1	34 912 ↓6.8	37 231 ↑6.6	37 686 ↑1.2	36 554 ↓3.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	11 817 =0.0	6 959 ↓41.1	8 532 ↑22.6	7 459 ↓12.6	5 505 ↓26.2
Үүнээс: эмэгтэй	хүн	6 040 ↓8.8	3 988 ↓34.0	4 628 ↑16.0	4 022 ↓13.0	3 007 ↓25.2
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	37 594 ↑0.2	24 869 ↓33.8	20 620 ↓17.1	21 950 ↑6.5	16 218 ↓26.1
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	16 689 ↑1.5	19 631 ↑17.6	23 855 ↑22.0	19 222 ↓19.4	14 117 ↓26.6
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.7 ↓0.1	-0.1 ↑0.8	2.2 ↑2.3	0.1 ↓2.10	0.7 ↑0.6
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	2 467 ↑23.6	2 444 ↑0.9	2 627 ↑7.5	2 715 ↑3.3	2850 ↑5.0
Нийслэлийн төсвийн орлого, өссөн дүнгээр	тэрбум төгрөг	767.8 ↑6.9	613.6 ↓20.1	754.9 ↑23.0	815.3 ↑9.6	733.5 ↓10.0
Нийслэлийн төсвийн зарлага, өссөн дүнгээр	тэрбум төгрөг	899.6 ↑19.6	854.2 ↓5.0	1 125.1 ↑31.7	1 136.9 ↑1.0	1 092.3 ↓3.9

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ↑, ↓ эерэг өөрчлөлтийн хувь;
↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
= тогтвортой

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2019 оны XI сард					2020 оны XI сард				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	306	Баянгол	7 642	Налайх	54	317	Баянгол	7 767	Налайх	56
			Чингэлтэй	1 811	Багануур	47		Чингэлтэй	1 719	Багануур	47
			Сүхбаатар	672	Багахангай	30		Сүхбаатар	706	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	95	Багахангай	285	Баянзүрх	66	63	Багахангай	811	Хан-Уул	50
			Багануур	213	Хан-Уул	64		Багануур	122	Баянзүрх	48
			Налайх	152	Сонгинохайрхан	53		Налайх	98	Сонгинохайрхан	27
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Налайх	15	Баянгол	10	12	Багахангай	25	Багануур	7
			Сүхбаатар	13	Хан-Уул	10		Сонгинохайрхан	13	Хан-Уул	6
			Сонгинохайрхан	12	Багахангай	10		Налайх	11	Сүхбаатар	4
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	125	Баянзүрх	172	Баянгол	110	111	Налайх	101	Сүхбаатар	71
			Сонгинохайрхан	159	Налайх	91		Багануур	94	Хан-Уул	66
			Чингэлтэй	121	Багахангай	29		Баянзүрх	90	Багахангай	26
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	67	Сүхбаатар	74	Налайх	13	67	Хан-Уул	61	Багануур	11
			Чингэлтэй	63	Багануур	10		Чингэлтэй	57	Налайх	10
			Хан-Уул	54	Багахангай	7		Сүхбаатар	51	Багахангай	7
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	259	Сүхбаатар	421	Налайх	152	145	Сүхбаатар	209	Сонгинохайрхан	102
			Чингэлтэй	319	Багануур	126		Чингэлтэй	168	Багахангай	86
			Баянзүрх	286	Багахангай	93		Баянзүрх	164	Багануур	70

Тайлбар: * промилль ** продицимил




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэлийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сард 5505 болж, өмнөх оны мөн үеэс 1954 (26.2%) хүнээр буурч, өмнөх сараас 92 (1.7%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй нийт ажилгүй иргэдийн 3007 (54.6%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Бүртгэлтэй ажилгүй иргэд, дүүргээр, нийслэлийн дүнд эзлэх хувиар, XI сарын эцэст

а. Бүртгэлтэй нийт ажилгүй иргэд



б. Хөгжлийн бэрхшээлтэй, бүртгэлтэй ажилгүй иргэд



Нийслэлийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 116 (2.1%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 64 (55.2%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй нийт ажилгүй иргэдийн 1095 (22.5%) нь Баянзүрх, 1237 (19.9%) нь Баянгол, 881 (16.0%) нь Чингэлтэй, 633 (11.5%) нь Сүхбаатар, 533 (9.7%) нь Сонгинохайрхан, 508 (9.2%) нь Хан-Уул, 208 (3.8%) нь Багануур, 213 (3.9%) нь Налайх, 197 (3.5%) нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 11 дүгээр сарын эцэст ажилгүй 2361 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 629 иргэн ажилд зуучлагдан орж, 1640 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Нийслэлийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс ажилд зуучлагдан орсон иргэд 613 (49.4%) хүнээр, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 1425 (53.5%) хүнээр, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 879 (27.1%) хүнээр тус тус буурсан байна.

Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, XI сарын эцэст



2019 XI 3 240 1 242

2020 XI 2 361 629




Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд



Ажилд зуучлагдан орсон иргэд

Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон игэд, дүүргээр, 2020 оны XI сар




Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, дүүргээр, жил бүрийн X, XI сарын эцэст

Дүүрэг	2017		2018		2019		2020	
	X	XI	X	XI	X	XI	X	XI
Нийслэлийн дүн	6 847	6 959	10 342	8 532	7 284	7 459	5 413	5 505
Багануур	516	396	393	395	304	262	168	208
Багахангай	160	98	147	73	204	205	211	197
Баянгол	961	985	783	898	1 413	1 414	1 120	1 237
Баянзүрх	1 418	1 467	4 099	3 292	1 571	1 790	1 144	1 095
Налайх	202	154	139	121	241	253	205	213
Сонгинохайрхан	1 168	1 369	1 763	1 427	1 000	892	582	533
Сүхбаатар	1 127	1 208	1 007	836	862	901	576	633
Хан-Уул	656	635	732	688	673	698	570	508
Чингэлтэй	639	647	1 279	802	1 016	1 044	837	881

Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1937 (35.2%) нь 25-34 насны залуучууд, 1446 (26.3%) нь 35-44 насныхан, 1184 (21.5%) нь 45-аас дээш насныхан, 938 (17.0%) нь 15-24 насныхан байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2020 оны XI сар



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 11 дүгээр сард 2361 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл хамгийн их буюу 67.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Зураг 5. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайн шинээр бүртгүүлсэн иргэд, ажил хайж буй шалтгаанаар, XI сарын эцэст



Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, XI сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүй иргэдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2018	2019	2020	2018	2019	2020
Ажилгүйчүүд, бүгд	8 532	7 459	5 505	100.0	100.0	100.0
Үүнээс:						
Магистр, доктор	227	161	126	2.5	2.1	2.4
Дипломын болон бакалаврын дээд	3 451	2 709	1 749	39.8	38.8	30.7
Тусгай мэргэжлийн дунд боловсролтой	381	313	204	4.4	4.3	3.9
Техникийн болон мэргэжлийн	287	239	174	3.6	3.7	3.3
Бүрэн дунд	3 877	3 708	3 022	46.3	47.1	55.5
Суурь	214	198	151	2.3	2.5	2.7
Бага	50	34	29	0.5	0.5	0.6
Боловсролгүй	45	97	50	0.5	1.0	0.9

2020 оны 11 дүгээр сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн албадаар зуучлагдан ажилд орсон 629 хүний 34 (5.4%) нь төрийн бус байгууллагад, 154 (24.5%) нь төсөвт байгууллагад, 441 (70.1%) нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд орсон байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны эхний 11 сард 781.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 284.2 (15.5%) тэрбум төгрөгөөр буурч, зарлага 1231.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.8 (2.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

2020 оны эхний 11 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 31.3 мянган байгууллага, 712.3 мянган иргэн хамрагдаж, 781.1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 511.9 мянга (71.9%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 123.7 мянга (17.4%) нь төсөвт байгууллагын, 76.7 мянга (10.8%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 22.7 мянган (3.1%) даатгуулагчаар буурсан байна.

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг, сараар




2020 оны эхний 11 сард нийгмийн даатгалын сангийн нийт орлого 781.1 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 104.9 тэрбум төгрөгөөр (13.4%) илүү бүрдсэн байна.

Хүснэгт 5. Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийслэлийн дүн	676 171.2	781 096.5	143.3	57 115.7
Багануур	8 457.2	13 690.3	161.9	5 233.1
Багахангай	947.9	1 522.5	160.6	574.6
Баянгол	118 876.5	134 101.5	112.8	15 225.0
Баянзүрх	95 711.5	96 927.3	101.3	1 215.8
Налайх	7 053.8	7 637.8	108.3	584.0
Сонгинохайрхан	49 687.7	49 746.1	100.1	58.4
Сүхбаатар	147 835.3	168 722.3	114.1	20 887.0
Хан-Уул	115 725.5	119 757.2	103.5	4 031.7
Чингэлтэй	131 875.8	188 991.5	143.3	57 115.7

Нийгмийн даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 81.5 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 8.6 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 7.8 хувь нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 2.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 7. Даатгалын сангийн зарлага, хувиар, XI сарын эцэст



2020 оны эхний 11 сард нийслэлийн нийгмийн даатгалын сангаас даатгуулагч, иргэдэд 1231.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын 82.4 хувийг тэтгэврийн, 7.6 хувийг тэтгэмжийн, 4.3 хувийг ҮОМШӨ-ний, 5.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн зарлага 2020 оны эхний 11 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар

буурсан бол ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага хамгийн өндөр буюу 121.7 хувиар өсч, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага хамгийн бага буюу 40.9 хувиар буурсан байна.

Зураг 8. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



2020 оны эхний 11 сард тэтгэвэрийн даатгалын сангаас 1014.1 тэрбум төгрөгийн зарлага гаргаснаас өндөр насны тэтгэвэр авагч 139.1 мянган хүнд 685.1 тэрбум (67.6%) төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч 24.5 мянган хүнд 85.3 тэрбум (8.4%) төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 7.1 мянган

хүнд 25.8 тэрбум (2.5%) төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 12.1 мянган хүнд 89.8 тэрбум (8.9 %) төгрөгийг тус тус олгосон байна. Тэтгэврийн даатгалын сангийн зарлагын (12.6%) буюу 127.3 тэрбум төгрөгийг бусад зардалд зарцуулжээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 63.2 мянган хүнд 12.0 тэрбум төгрөгийн, жирэмсэн болон амаржсан 33.6 мянган эхэд 64.2 тэрбум төгрөгийн, 5.1 мянган иргэний ар гэрт 5.1 тэрбум төгрөгийн оршуулгын тэтгэмжийг тус тус олгож, 11.9 тэрбум төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна.



ЭРҮҮЛ МЭНД


Нийслэлийн хэмжээнд 2020 оны эхний 11 сард 36176 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1159 (3.1%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 23193 (64.1%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 12983 (35.9%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 3.5 хувийг өсвөр насны охидын төрөлт, 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 11 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	$\frac{2020}{2019}$ %
Амаржсан эхийн тоо	36 922	37 335	36 176	-3.1
Гэрийн төрөлт	160	118	114	-3.4
Хяналтгүй төрөлт	214	222	180	-18.9
Амьд төрсөн хүүхэд	37 231	37 686	36 554	-3.0
Эхийн эндэгдэл	11	10	11	10.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	497	490	431	-12.0
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.3	13.0	11.8	-

2020 оны эхний 11 сард 36554 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1132 (3.0%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт хүүхдийн 6853 (18.7%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


Зураг 9. Амьд төрсөн хүүхэд, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 18707 (51.2%) нь эрэгтэй, 17847 (48.8%) нь эмэгтэй хүүхэд байна. Амьд төрсөн нийт хүүхдийн 552 нь 2 ихэр, 19 нь 3 ихэр хүүхэд байна. Мөн 3.3 хувь нь 2500 граммаас бага жинтэй, 0.5 хувь нь төрөлхийн гажигтай төржээ.

Амьгүй төрөлтийн 203 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 тохиолдолоор буурсан байна. Амьгүй төрөлт Чингэлтэй, Багануур, Багахангай дүүрэгт хотын дунджаас өндөр байна.


Зураг 10. Хүүхдийн эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлтөд ногдох), дүүргээр, XI сарын байдлаар



Нялхсын эндэгдлийн 59 (13.7%) нь Баянзүрх, 82 (19.0%) нь Сонгинохайрхан, 29 (6.7%) нь Чингэлтэй, 41 (9.5%) нь Баянгол, 27 (6.3%) нь Хан-Уул, 9 (2.1%) нь Сүхбаатар, 4 (0.9%) нь Багануур, 9 (2.1%) нь Налайх, 2 (0.5%) нь Багахангай, 169 (39.2%) нь бусад аймгийн харьяат байна.

Нийслэлд 2020 оны эхний 11 сард 16218 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 5732 (26.1%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 42.1 продицимилээр тус тус буурсан байна.

Зураг 11. Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 1979 (12.2%) нь цусан суулга, 1532 (9.4%) нь салхин цэцэг, 3515 (21.7%) нь тэмбүү, 1949 (12.9%) нь сүрьеэ, 346 (2.4%) нь ковид-19, 722 (5.1%) нь гар хөл амны өвчин, 1753 (10.8%) нь трихомониаз, 1966 (13.9%) нь гонококкт халдвар, 161 (1.1%) нь улаан эсэргэнэ, 158 (1.1%) сальмонеллэз, 116 (0.8%) нь хоолны хордлого, 161 (1.1%) нь вируст гепатит, 39 (0.3%) гахайн хавдар өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Эхний 11 сарын байдлаар **Коронавируст халдвар /COVID-19/-ын** 520 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 3.2 хувийг эзэлж байна. Тухайн сард бүртгэгдсэн 174 тохиолдлын 137 нь дотоодын халдвар, 37 нь зөөвөрлөгдөн орж ирсэн байна.

Хүснэгт 7. Нийслэлд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний 11 сард

Төрөл	Хэмжих нэгж	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	Өсөлт, бууралт 2020/2019	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	20 620	21 950	16 218	-5 732	-26.1
	10000 хүнд	147.4	153.4	111.3	-42.1	
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо	271	213	170	-43	-20.2
	10000 хүнд	1.9	1.5	1.2	-0.3	
Цусан суулга	бодит тоо	4 906	4 434	1 979	-2 455	-55.4
	10000 хүнд	35.1	31.0	13.6	-17.4	
Салхин цэцэг	бодит тоо	4 069	5 659	1 532	-4 127	-72.9
	10000 хүнд	29.1	39.5	10.5	-29	
Гахай хавдар	бодит тоо	208	42	41	-1	-2.4
	10000 хүнд	1.5	0.3	0.3	0.0	
Сальмонеллөз	бодит тоо	287	261	160	-101	-38.7
	10000 хүнд	2.1	1.8	1.1	-0.7	
Улаан эсэргэнэ	бодит тоо	764	712	173	-539	-75.7
	10000 хүнд	5.5	5.0	1.2	-3.8	
Хоолны хордлого	бодит тоо	273	664	117	-547	-82.4
	10000 хүнд	2.0	4.6	0.8	-3.8	
Ёлом	бодит тоо	110	137	88	-49	-35.8
	10000 хүнд	0.8	1.0	0.6	-0.4	
Бруцеллөз	бодит тоо	12	16	10	-6	-37.5
	10000 хүнд	0.1	0.1	0.1	0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1 637	1 341	973	-368	-27.4
	10000 хүнд	11.7	9.4	6.7	-2.7	
Ковид 19	бодит тоо	-	-	520	520	-
	10000 хүнд	-	-	3.6	3.6	
Тэмбүү	бодит тоо	2 491	3 215	3 515	300	9.3
	10000 хүнд	17.8	22.5	24.1	1.6	
Гонококкт халдвар	бодит тоо	1 609	1 630	2 127	497	30.5
	10000 хүнд	11.5	11.4	14.6	3.2	
Трихомониаз	бодит тоо	1 787	1 412	1 753	341	24.2
	10000 хүнд	12.8	9.9	12.0	2.1	
Сүрьеэ	бодит тоо	1 932	1 953	1 949	-4	-0.2
	10000 хүнд	13.8	13.6	13.4	-0.2	
ДОХ	бодит тоо	17	16	22	6	37.5
	10000 хүнд	0.1	0.1	0.15	0.05	



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2020 оны 11 дүгээр сард дунджаар -16.1°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -6.1°C -аар сэрүүн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 8.7°C , хамгийн хүйтэн хэм -24.0°C , хур тунадасны нийлбэр 7.1 мм, шороон болон цасан шуургатай өдөр бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 8. Агаарын бохирдолт, мг/м^3 , XI сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	342	0.435	164	0.077
Азотын давхар исэл	NO ₂	0.050	267	0.075	62	0.037
Тоосжилт	PM ₁₀	0.100	347	0.358	135	0.097
	PM _{2.5}	0.050	253	0.163	105	0.050
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	966	11.772	2	1.829
Озон	O ₃	0.100	679	0.076	0	0.020


2020 оны 11 дүгээр сард хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Мишээл Экспо орчимд 5 удаа, Баруун 4 зам орчимд 11 удаа, 13-р хороолол орчимд 14 удаа, 32-н тойрог орчимд 16 удаа, Хархорин зах орчимд 7 удаа, Ургах наран хороолол орчимд 6 удаа, Хайлааст орчимд 24 удаа, 248-р цэцэрлэг орчимд 17 удаа, Богд хааны ордон музей орчимд 4 удаа, Нисэх орчимд 26 удаа, Зурагт орчимд 27 удаа, Амгалан орчимд 7 удаа, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 17 удаа, 13-р хороолол орчимд 11 удаа, 32-н тойрог орчимд 9 удаа, Хархорин зах орчимд 11 удаа, Хайлааст орчимд 1 удаа, Нисэх орчимд 1 удаа, Зурагт орчимд 11 удаа, Амгалан орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Мишээл экспо төв орчимд 4 удаа, Баруун 4 зам орчимд 10 удаа, 1-р хороолол орчимд 8 удаа, 13-р хороолол орчимд 12 удаа, 32-н тойрог орчимд 17 удаа, Хархорин зах орчимд 19 удаа, Ургах наран хороолол орчимд 15 удаа, 248-р цэцэрлэг орчимд 7 удаа, Богд хааны ордон музей орчимд 11 удаа, Нисэх орчимд 10 удаа, Толгойт орчимд 3 удаа, Зурагт орчимд 9 удаа, Амгалан орчимд 10 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.


¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж


Зураг 12. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 13. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 9 харуулын дундаж, сараар, мг/м³




Зураг 14. Улаанбаатар³ хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.

Зураг 15. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 14 харуулын дундаж, сараар, мг/м³



Хүснэгт 9. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, X сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	I хороолол	XIII хороолол	32-ын тойрог	Офицеру у- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Хайлааст	248-р цэцэрлэг	Богд хааны ордон музей	Нисэх	Толгойт	Зурагт	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.030	0.052	-	0.051	0.095	0.041	0.037	0.145	0.166	0.028	0.091	-	0.146	0.038	0.030
	Хамгийн их	0.087	0.123		0.134	0.366	0.113	0.118	0.429	0.435	0.082	0.226	-	0.302	0.153	0.087
	XXX*-с давсан хувь	17.0	38.0	-	47.0	53.0	23.0	22.0	83.0	85.0	14.0	87.0	-	97.0	23.0	17.0
	Хэмжилтийн тоо	30	29	-	30	30	30	27	29	20	29	30	-	28	30	30
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.050	-	0.045	0.045	0.045	0.013	0.026	-	-	0.033	-	0.043	0.032	-
	Хамгийн их	-	0.068	-	0.067	0.075	0.068	0.027	0.052	-	-	0.052	-	0.072	0.059	-
	XXX*-с давсан хувь	-	57.0	-	37.0	30.0	37.0	0.0	3.0	-	-	3.0	-	39.0	3.0	-
	Хэмжилтийн тоо	-	30	-	30	30	30	30	29	-	-	30	-	28	30	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	1.472	2.543	0.993	1.813	1.004	0.818	3.284	-	0.698	1.362	3.245	3.435	1.284	-
	Хамгийн их	-	5.173	6.501	4.458	5.222	3.284	2.658	11.772	-	6.825	3.845	9.960	8.692	4.459	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	2.0	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	90	55	90	90	90	36	90	-	70	90	90	85	90	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.074	0.090	0	0.097	0.113	0.137	0.109	0.127	0.089	0.081	0.092	0.066	0.083	0.086	0.074
	Хамгийн их	0.146	0.183	0	0.177	0.239	0.230	0.195	0.358	0.199	0.170	0.182	0.105	0.134	0.200	0.146
	XXX*-с давсан хувь	16.0	33.0	47.0	40.0	57.0	63.0	56.0	59.0	35.0	55.0	33.0	10.0	32.0	33.0	16.0
	Хэмжилтийн тоо	25	30	17	30	30	30	27		20	20	30	30	28	30	25
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.053	0.056	0.031	-	-	-	0.075	0.057	0.028	0.042	0.050	0.065	0.042	-
	Хамгийн их	-	0.099	0.112	0.064	-	-	-	0.163	0.098	0.088	0.073	0.091	0.113	0.096	-
	XXX*-с давсан хувь	-	43.0	47.0	3.0	-	-	-	68.0	59.0	25.0	30.0	47.0	75.0	27.0	-
	Хэмжилтийн тоо	-	30	17	30	-	-	-	25	17	16	30	30	28	30	-
Озон O ₃ **	Дундаж	0.011	-	0.011	0.012	0.020	-	0.024	-	-	-	0.031	0.013	0.010	0.051	0.011
	Хамгийн их	0.030	-	0.023	0.046	0.048	-	0.059	-	-	-	0.076	0.049	0.042	0.068	0.030
	XXX*-с давсан хувь	0.0	-	0.0	0.0	0.0	-	0.0	-	-	-	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хэмжилтийн тоо	90	-	55	90	58	-	90	-	-	-	90	90	87	29	90

* Хүлцэх хэм хэмжээ, **CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Хүснэгт 10. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Төрөл	2017		2018		2019		2020	
	X	XI	X	XI	X	XI	X	XI
	төгрөг							
Тэмээний шир	17 500	17 500	7 000	7 500	15 000	16 000	80 000	60 000
Адууны шир	19 333	21 333	10 000	10 666	7 670	8 670	13 250	10 500
Үхрийн шир	33 333	36 667	13 500	14 333	4 670	4 500	7 700	6 625
Хонины арьс	4 750	5 000	2 150	1 233	2 750	2 170	3 250	1 750
Ямааны арьс (ноолуургүй)	17 666	24 000	21 670	-	8 000	21 670	-	-
Ямааны ноолуур	70 000	-	80 000	90 000	60 000	60 000	60 000	-

Багануур дүүргийн түүхий эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 1 000 000 төгрөг, үхэр 1 200 000 төгрөг, эр хонь 200 000 төгрөг, эм хонь 150 000 төгрөг, эр ямаа 150 000 төгрөгийн үнэ ханштай байна.

Нийслэлийн түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 60 000 төгрөг, адууны шир 10 500 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 4 000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 9 250 төгрөгийн ханштай байна.




ГЭМТ ХЭРЭГ

2020 оны эхний 11 сард 14117 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5105 (26.6%) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 46.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.0 пунктээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 4516 хүн гэмтэж осолдон, 278 хүн нас барж, төр ард иргэдэд 222.3 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 63.9 тэрбум (28.8%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 16. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 25.1 хувийг хулгайн, 30.6 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 24.1 хувийг залилан, 2.4 хувийг дээрмийн, 3.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.6 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 0.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.4 хувийг хүчин, 0.7 хувийг хүн амь, 11.3 хувийг бусад гэмт хэрэг түс түс эзэлж байна.

Хүснэгт 11. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний XI сарын эцэст


Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2020/2019	
	2018 I-X	2019 I-X	2020 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	23 855	19 222	14 117	-5 105	-26.6
Хүний амь	94	105	95	-10	-9.5
Хүчин	251	221	191	-30	-13.6
Дээрэм	1 339	719	338	-381	-53.0
Хулгай	9 053	6 274	3 546	-2 728	-43.5
Залилан	4 253	3 630	3 406	-224	-6.2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	5 388	4 806	4 315	-491	-10.2
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	477	547	428	-119	-21.8
Бусдыг амиа хорлоход хүргэх	255	204	90	-114	-55.9
Ашиглах	325	323	223	-100	-31.0
Танхайрах	34	17	9	-8	-47.1
Бусад	2 386	2 376	1 476	-900	-37.9

2020 оны эхний 11 сард 65591 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20413 (45.2%) хүнээр өссөн байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний XI сард

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2020/2019	
	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	23 855	19 222	14 117	-5 105	-26.6
Багануур	243	169	135	-34	-20.1
Багахангай	25	15	24	9	60.0
Баянгол	4 214	2 895	2 160	-735	-25.4
Баянзүрх	7 157	5 162	3 955	-1 207	-23.4
Налайх	392	319	321	2	.6
Сонгинохайрхан	3 251	3 266	2 234	-1 032	-31.6
Сүхбаатар	3 900	3 040	2 078	-962	-31.6
Хан-Уул	2 601	1 881	1 494	-387	-20.6
Чингэлтэй	2 072	2 475	1 716	-759	-30.7

Зураг 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүрэг, хувиар, 2020 оны эхний XI сард




2020 оны эхний 11 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12076 (85.5%) нь хөнгөн хэрэг, 2041 (14.5%) нь хүнд хэрэг байна.⁴

⁴ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

Хүснэгт 13. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2020 оны эхний XI сард

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	11 517	5 341	46.4
Багануур	65	35	53.8
Багахангай	17	11	64.7
Баянгол	1 999	1 202	60.1
Баянзүрх	2 935	1 300	44.3
Налайх	249	133	53.4
Сонгинохайрхан	1 862	894	48.0
Сүхбаатар	1 711	677	39.6
Хан-Уул	1 312	572	43.6
Чингэлтэй	1 367	517	37.8

Зураг 18. Гэмт хэргийн илрүүлэлт, 2020 оны эхний XI сард



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2020 оны эхний 11 сард 8768 болж, өмнөх оны мөн үеэс 89 (1.0%) хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 2371 (27.0%) нь согтуугаар, 1006 (11.5%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 521 (5.9%) нь хүүхэд, 1979 (22.6%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 14. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний XI сард

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI
Нийслэлийн дүн	9 053	6 274	3 546	7 462	5 573	3 197
Багануур	63	37	24	58	30	22
Багахангай	7	2	6	7	2	5
Баянгол	1 384	861	318	1 048	711	250
Баянзүрх	3 111	1 774	1 014	2 338	1 549	870
Налайх	132	85	56	123	82	50
Сонгинохайрхан	1 271	1 213	710	1 184	1 140	677
Сүхбаатар	1 462	932	547	1 097	849	506
Хан-Уул	957	532	436	889	459	413
Чингэлтэй	666	838	435	605	751	404




НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2020 оны эхний 11 сард 733.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 364.5 тэрбум төгрөгөөр (33.2%) дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 87.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 12.4 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2020 оны эхний 11 сард нийслэлийн татварын орлого 642.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 306.1 тэрбум төгрөгөөр (32.3%), татварын бус орлого 91.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 58.4 тэрбум төгрөгөөр (39.0%) тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 222.7 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 29.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрджээ.

Зураг 19. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 15. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс:					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
Нийслэлийн дүн	1 097 956.9	733 482.5	- 33.2	948 393.0	642 295.2	-32.3	149 563.9	91 187.3	-39.0
Багануур	2 039.4	2 172.8	6.5	1 353.9	1 444.0	6.7	685.5	728.8	6.3
Багахангай	326.8	368.9	12.9	144.7	130.8	-9.6	182.1	238.1	30.8
Баянгол	32 436.1	25 593.5	- 21.1	28 957.7	23 919.5	-17.4	3 478.4	1 674.0	-51.9
Баянзүрх	46 884.3	34 295.6	- 26.9	45 411.3	33 417.3	-26.4	1 473.0	878.3	-40.4
Налайх	2 797.0	2 239.7	- 19.9	2 275.0	1 428.4	-37.2	522.0	811.3	55.4
Сонгинохайрхан	21 729.6	15 680.3	- 27.8	20 064.9	14 760.5	-26.4	1 664.7	919.8	-44.7
Сүхбаатар	86 206.6	52 211.6	- 39.4	83 149.1	50 249.7	-39.6	3 057.5	1 961.9	-35.8
Хан-Уул	46 788.8	49 800.1	6.4	43 885.7	47 222.6	7.6	2 903.1	2 577.5	- 11.2
Чингэлтэй	54 889.2	50 145.4	- 8.6	51 804.8	47 148.2	-9.0	3 084.4	2 997.2	- 2.8
Хотын шууд	803 859.1	500 974.6	- 37.7	671 345.9	422 574.2	-37.1	132 513.2	78 400.4	-40.8

Хүснэгт 16. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая төгрөг
Нийт орлого	1 097 956.9	733 482.4	- 33.2	- 364 474.5
1. Татварын орлого	948 393.0	642 295.2	- 32.3	- 306 098.0
Орлогын албан татвар	684 777.3	462 073.0	- 32.5	- 222 704.5
Хувь хүний орлогын албан татвар	712 777.3	482 335.1	- 32.3	- 230 442.4
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	513 200.0	308 033.7	- 40.0	- 205 166.3
Үйл ажиллагааны орлогын	26 573.6	36 696.8	38.1	10 123.2
Хөрөнгийн орлого	89 055.8	89 229.4	0.2	173.6
Хөрөнгө борлуулсны орлогын	10 390.7	12 448.1	19.8	2 057.4
Шууд бус орлого	73 557.2	35 927.1	- 51.2	- 37 630.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 28 000.0	- 20 262.1	- 27.6	7 737.9
Хөрөнгийн албан татвар	102 789.9	73 444.2	- 28.5	- 29 345.8
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	72 449.9	45 477.8	- 37.2	- 26 972.1
Бууны албан татвар	440.0	285.6	- 35.1	- 154.4
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	29 900.0	27 680.8	- 7.4	- 2 219.2
Бусад татвар, төлбөр, хураамж	160 825.8	106 778.0	- 33.6	- 54 047.8
Бусад нийтлэг төбөр, хураамж	46 053.8	39 789.9	- 13.6	- 6 263.9
Газрын төлбөр	102 423.1	59 046.3	- 42.4	-43 376.8
Байгалийн нөөц ашигласны төлбөр	4 222.9	3 158.7	- 25.2	- 1 064.2
Бусад татвар	8 126.0	4 783.1	- 41.1	- 3 342.9
2. Татварын бус орлого	149 563.9	91 187.2	- 39.0	- 58 376.6
Нийтлэг татварын бус орлого	79 790.5	70 435.9	- 11.7	- 9 354.5
Хувьцаа ногдол ашиг, Хүүгийн орлого	965.0	462.6	- 52.1	- 502.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	12 622.2	8 072.2	- 36.0	- 4 550.0
Торгуулийн орлого	47 222.2	43 739.3	- 7.4	- 3 482.9
Түрээсийн орлого	2 945.0	2 289.6	- 22.3	- 655.4
Бусад нэр заагдаагүй орлого	16 036.1	15 872.2	- 1.0	- 163.9
Өмч хувьчлал	69 773.4	20 751.3	- 70.3	- 49 022.1

2020 оны эхний 11 сард нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 61.3 хувийг (1092.2 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 38.7 хувийг (690.3 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.


Хүснэгт 17. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

Дүүрэг	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийслэлийн дүн	733 482.5	1 782 519.2	1 092 229.1	- 38.7	- 690 290.1	- 358 746.6
Багануур	2 172.8	22 166.7	19 053.4	- 14.0	- 3 113.3	- 16 880.6
Багахангай	368.9	6 467.7	5 574.0	- 13.8	- 893.7	- 5 205.1
Баянгол	25 593.5	109 213.4	92 095.1	- 15.7	- 17 118.3	- 66 501.6
Баянзүрх	34 295.6	147 533.0	118 870.0	- 19.4	- 28 663.0	- 84 574.4
Налайх	2 239.7	25 084.8	21 956.3	- 12.5	- 3 128.5	- 19 716.6
Сонгинохайрхан	15 680.3	121 476.1	109 829.7	- 9.6	- 11 646.4	- 94 149.4
Сүхбаатар	52 211.6	163 387.8	102 176.8	- 37.5	- 61 211.0	- 49 965.2
Хан-Уул	49 800.1	110 326.6	87 216.3	- 20.9	- 23 110.3	- 37 416.2
Чингэлтэй	50 145.4	104 069.7	82 437.3	- 20.8	- 21 632.4	- 32 291.9
Хотын шууд	500 974.6	972 793.4	453 020.2	- 53.4	- 519 773.2	47 954.4

Зураг 20. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 21. Төсвийн орлого, зарлага, сая төгрөг






ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2020 оны 11 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2019 оны эцэстэй харьцуулахад 3.7 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 22. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2020 оны 11 дүгээр сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 3.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 8.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 5.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 3.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 5.6 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 2.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 3.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний үнэ 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 0.7 хувиар, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.7 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 4.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 18. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2019-XI</u> 2018-XI	<u>2020-XI</u> 2019-XI	<u>2020-XI</u> 2019-XII	<u>2020-XI</u> 2020-X
Ерөнхий индекс	105.0	104.3	103.7	100.7
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	109.3	108.7	108.1	101.7
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.7	105.5	105.0	100.2
Хувцас, бөс бараа, гутал	108.3	104.7	103.2	100.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	102.5	106.0	105.6	102.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.0	103.1	102.4	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.4	103.3	103.0	100.5
Тээвэр	96.0	96.8	96.1	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.1	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	115.9	100.8	100.7	100.0
Боловсролын үйлчилгээ	107.0	100.6	100.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	109.5	105.8	105.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.6	106.5	104.3	100.0

